НЗД-ын 1993 оны А282-р захирамжаар хүчингүй.

БНМАУ-ЫН ХУДАЛДАА БЭЛТГЭЛИЙН ЯАМНЫ КОЛЛЕГИ, УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ГИШҮҮДИЙН ХАМТАРСАН ХУРЛЫН ТОГТООЛ

1985 оны 12 дугаар сарын 31 ны өдөр

Дугаар 234/362

Улаанбаатар хот

VII - 6

Нийтийн хоолны түргэн үйлчилгээний цэг салбар байгуулах тухай

Улаанбаатар хотын хүн ам өсөн нэмэгдэж, шинэ үйлдвэр, албан байгууллага олноороо байгуулагдаж байгаатай холбогдуулан нийтийн хоолны үйлчилгээний хүрээг өргөтгөн, түргэн үйлчилгээний төрөлжсөн цэг салбарыг олноор нэмж ажиллуулах шаардлагатай байгааг тэмдэглэн БНМАУ-ын Худалдаа, бэлтгэлийн яамны коллеги, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны гишүүдийн хамтарсан хурлаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотод нийтийн хоолны түргэн үйлчилгээний цэг салбар байгуулах, түүнд засвар тохижилт хийх байгууллага, хүмүүсийг 1 хавсралтаар баталсугай.

2. Сүхбаатарын районы орон сууц гудамжны 29 дүгээр хорооны 34 дүгээр байрны хүүхдийн хэстийн эмнэлэг байрлаж байсан байрыг нийтийн хоолны төрөлжсөн түргэн үйлчилгээний цэг болгохоор Нийтийн хоолны удирдах газарт 1986 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн түрээсээр эзэмшүүлэхийг Орон сууц, нийтийн аж ахуй удирдах газар /н.БААСАНЖАВ/-т даалгасугай.

3. Энх тайвны гудамжинд байрладаг цэцгийн дэлгүүрийг тавилгаа, орон тоо, тоног төхөөрөмжийн хамт 1986 оны 1 дүгээр сарын 1-ний дотор суллаж өгөхийг Улаанбаатар хотын Хот тохижуулах газар /н.БАДРАХ/, цэцгийн худалдааг Улсын их дэлгүүрт тусгай байр гарган тасаг нээж ажиллахыг Улсын их дэлгүүр /н.БАДАРЧ/ нарт даалгасугай.

4. 1 хороололд 1986 оны эхний ээлжинд ашиглалтанд орох орон сууцны байраас 4 айлын сууцыг нийтийн хоолны зориулалтаар ашиг-

дуулахаар хотын Нийтийн хоолны удирдах газарт хуваарилан олго-хыг Орон сууц, нийтийн үйлчилгээний хэлтэс /н.ДАВИС/-т даалга-сугай.

5.Ард, Элдэв-Очир кино театр, Дуурь, драмын академик театр, Улсын циркийн дэргэдэх зууш, буфетэнд худалдаалах зүйлийн нэр төрлийг олшруулан үйлчилгээг сайжруулах талаар хамтран ажилла-хыг хотын нийтийн хоолны удирдах газар /н.УРИАНХАЙ/, хотын Соёлын хэлтэс /н.МӨНХӨӨ/-д даалгасугай.

6.Улсын их дэлгүүрийн 2 дугаар давхарт энэ онд багтаан өөрийн гуанзнаас буфет гаргаж ажиллуулахыг Улсын их дэлгүүр /н.БАДАРЧ/-т даалгасугай.

7.Түргэн үйлчилгээний цэг салбар нээж ажиллуулахад шаар-дагдах П хавсралтанд дурдсан тоног төхөөрөмж, багаж хэрэгслэ-лийг дурдсан хугацаанд олгохыг Худалдаа, бэлтгэлийн яамны Хө-рөнгө оруулалт, материал хангамж нормчлолын хэлтэс /н.ЦАГААН-БААТАР/, хуваарьт газрын нэр заагдсан барилгад зураг төсвийн дагуу засвар хийхийг Худалдаа, бэлтгэлийн яамны барилга зас-варын контор /н.БАНЗРАГЧ/-д даалгасугай.

8.Түргэн үйлчилгээний цэг салбарын үйлчилгээнд шаардагдах хүнсний материалын фондыг хуваарилан олгох арга хэмжээ авахыг Худалдаа бэлтгэлийн яамны орлогч сайд н.ЦЭРЭН-ОЧИР, хотын тө-лөвлөгөөний комисс /н.ДУГАРЖАВ/-т даалгасугай.

9.Түргэн үйлчилгээний цэг салбар нээж ажиллуулахад шаардаг-дах орон тоо, цалингийн фондыг 1986 оны Нийтийн хоолны удирдах газрын орон тоо, цалингийн фондод оруулан баталж өгөхийг Хөдөл-мөр, цалин хөлсний хэлтэс /н.БАНЗРАГЧ/, хотын санхүүгийн хэлтэс /н.ЭРДЭМБАТ/, засвар тохижилт хийх, тоног төхөөрөмж авахад шаар-дагдах хөрөнгийг гаргахыг Худалдаа, бэлтгэлийн яамны орлогч сайд н.ПҮРЭВДОРЖИД даалгасугай.

10.Хотын нийтийн хоолны удирдах газар /н.УРИАНХАЙ/-д даалгах нь:

а/түргэн үйлчилгээний цэг салбарыг хугацаанд нь нээж, үйлчилгээнд нь өдөр тутмын хяналт тавьж ажилласугай.

б/Түргэн үйлчилгээний төрөлжсөн хоолтой гуанз, цайны газруудыг олшруулах үйлчилгээг соёлжуулах, бүтээгдэхүүний амт чанар, нэр төрлийг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсүгэй.

11.Энэ тогтоолын биелэлтэнд байнгын хяналт тавьж, гүйцэтгэлийг сар бүрээр гаргаж мэдээлж байхыг Худалдаа бэлтгэлийн яамны нийтийн хоолны хэлтэс /н.БАЯРСАЙХАН/, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны референт /н.ЦАГААН/-д даалгасугай.

ХУДАЛДАА БЭЛТГЭЛИЙН ЯАМНЫ САЙД Б.ШАРАВСАМБУУ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА С.МӨНХЖАРГАЛ

ХБЯ-ны коллеги, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны гишүүдийн 1985 оны р сарын ны өдрийн
тоот тогтоолын 1 дүгээр хавсралт.

# ШИНЭЭР НЭЭХ ТҮРГЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГ САЛБАР БАЙГУУЛЖ ТОХИЖУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Түргэн үйлчилгээний цэг салбарын нэр: Үйлчилгээний хэлбэр | Хүчин чадал суудлаар | Хаанахын байр | | Хугацаа: эхлэх | Хугацаа: дуусах | Байр бэлтгэх: Хариуцах байгууллага, хүн | Байр бэлтгэх: Засвар тохижилт хийх байгууллага, хүн | Үйлчилгээ гаргах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Буфет | 6 | МУИС | 8,5 | 10/XII | 25/XII | МУИС-ийн ректор Шагдарсүрэн | МУИС | 26-наас эхлэнэ |
| 2. Буфет | 6 | ПТДС | 8,0 | 10/XII | 25/XII | ПТДС-ийн ректор Авдай | ПТДС | 26-наас эхлэнэ |
| 3. Буфет | 6 | УБДС | 8,0 | 10/XII | 20/XII | УБДС-ийн ректор Отгонсүрэн | УБДС | 20 хоног ажиллана |
| 4. Буфет Бососо ширээ | 10 | ХАА-н дээд сургууль | 8,0 | 10/XII | 1/I | ХААДС-ийн ректор Санж | ХААДС | 1-р сарын 1-нээс |
| 5. Буфет | 6 | АУДуС | 8,0 | 10/XII | 20/XII | АУДуС-ийн | АУДуС | 20/XII-ноос |
| 6. Буфет | 8 | Барилгын техникум | 8,0 | 10/XII | 15/I | Барилгын техникумын захирал Жумдаан | Барилгын техникум | 1-р сарын 15-наас |
| 7. Буфет | 6/24 | Худалдааны ТМС | | 10/XII | 22/XII | Техник мэргэжлийн сургуулийн захирал Долгор | ХТМС | 22/XII-ноос |
| 8. Буфет | 8 | НААУТМС | 8,6 | 10/XII | 22/XII | Захирал Жаахан | НААУТМС | 22/XII-ноос |
| 9. Зуушны газар /Сосиска/ | 10 | ОСНААУ газрын ОСА р контор | 10,5 | 10/XII | 1/I | ОСНААУ газар Баасанжав | ОСНААУ газар | 1-р сарын 1-нээс |
| 10. -"- | 10 | Хот цэвэржүүлэх трест | 10,5 | 10/XII | 22/XII | | Хот цэвэржүүлэх трест | 1-р сарын 1-нээс |
| 11. Пирошкины цэг | - | ОСААУТ | 33,0 | 10/XII | 1/I | Москва ресторан Р.Алтанхуяг | ХБЯ-ны барилга контор | 1-р сарын 1-нээс |
| 12. -"- | - | ОСААУТ | 33,0 | 10/XII | 1/I | Сүхбаатарын трест Э.Даргаа | -"- | -"- |
| 13. Нэг удаа хэрэглэдэг сав үйлдвэрлэх цэг | - | ОСААУТ | 33,0 | 10/XII | 1/II | 12-р анги Д.Тогтох | -"- | -"- |
| 14. Пирошкины цэг | - | ТЗХЭТ | 25,0 | 10/XII | 1/I | Найрамдлын трест Д.Отгондазаа | -"- | 2-р сарын 1-нээс |
| 15. Цайны газар | 3 | АТҮТ | 40,0 | 1/I | 1/III | АТҮТ Тогтохбаяр | АТҮТ | 3-р сарын 5-наас |
| 16. Цайны газар кулинарын дэлгүүр | 8/32 | Орон сууц | 30,0 | 10/XII | | Хотын гүйцэтгэх захиргаа Давис | | 2-р сараас |
| 17. Уран бэр | 20/80 | Найрамдлын районы н/х трест | 30,0 | 10/XII | 16/XII | Найрамдлын трест Д.Отгондазаа<br>Хотын ХЗЭ-ийн хороо Энхмандах | Найрамдлын трест Д.Отгондаваа хариуцна | 2-р сарын 6-наас |
| 18. Буфет | 6 | Дуурийн театр | 6,3 | 10/XII | 15/XII | Дуурийн театрын дарга | Өөрсдийн хүчээр | 15/XII |
| 19. Буфет | 4 | Драмын театр | | 10/XII | 15/XII | Драмын театрын дарга | -"- | 15/XII-наас |
| 20. Зайрмагны байр | 4 | "Ард" кино театр | | 10/XII | 20/XII | Кино театрын дарга | -"- | 20/XII-ноос |
| 21. Зайрмагны байр | 4 | "Элдэв-Очир" -"- | | 10/XII | 20/XII | -"- | -"- | 20/XII-ноос |
| 22. Зайрмаг худалдаалах цэг | 8 | "Ард" кино театр | 10,0 | 10/XII | 1/I | Сүхбаатарын районы нийтийн хоолны трест Э.Даргаа | ХБЯ-ны барилга контор | 1-р сарын 1-нээс |
| ДҮН | 121/136 | | 319,8 | | | | | |

Худалдаа, бэлтгэлийн яамны коллеги, хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны гишүүдийн 1985 оны 12-р сарын ______ны өдрийн ______тоот тогтоолын хавсралт.

# ШИНЭЭР НЭЭГДЭХ ТҮРГЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГ САЛБАРУУДАД ШААРДАГДАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ.

| Байршил | | мороженын лангуу/ширхэг/ | хөргөх лангуу /ширхэг/ | ус буцалгагч | хөргөх шүүгээ | гэрийн хэрэгт | самовар | заслонка | тахилгаан шийгийн | I-р хоолны тогоо | 2-р хоолны тогоо | пирожкын автомат | пончикны автомат | кафе варка | кассын аппарат | тоолт жин | 50-ын шүү |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| I. Цирк | буфет | I | I | – | – | I | – | I | – | – | – | – | – | – | I | I | I |
| 2. Хуучин нүдний шилний газар | буфет | – | I | – | – | I | – | – | – | – | – | – | – | – | – | I | I |
| 3. Энхтайвны гудамж | Сосискны газар | – | – | – | – | – | – | – | I | – | – | – | – | – | I | I | I |
| 4. Худалдааны техникийн сургууль | буфет | – | – | – | – | I | – | – | – | – | – | – | – | – | I | I | I |
| 5. НААҮТМС | буфет | – | – | – | – | I | 2 | – | – | – | – | – | – | – | – | – | – |
| 6. УБДС-ийн I байр | буфет | – | I | – | – | I | 2 | I | – | – | – | – | – | – | – | I | I |
| 7. АУДуС-ийн байр | буфет | – | – | – | – | I | I | – | – | – | – | – | – | – | – | I | I |
| 8. ПДС-ийн II байр | буфет | – | I | – | – | I | 2 | I | – | – | – | – | – | – | – | I | I |
| 9. МУИС-ийн байр | буфет | – | I | – | – | – | 2 | I | – | – | – | – | – | – | – | – | – |
| I0. Пионер сурагчдын ордон | буфет | – | – | – | – | – | I | – | – | – | – | – | – | – | I | – | – |
| II. Дуурийн театр | буфет | – | – | – | – | I | 2 | I | – | – | – | – | – | – | – | – | – |
| I2. Драмын театр | буфет | – | – | – | – | – | 2 | I | – | – | – | – | – | – | I | I | – |
| I3. Элдэв-Очир кино театр | буфет | – | – | – | – | I | I | I | – | – | – | – | – | – | – | – | – |
| I4. Хотын номын сан | буфет | – | – | – | – | I | – | – | – | – | – | – | – | – | – | I | I |
| I5. Хүнсний ТМС | буфет | – | – | – | – | I | – | – | – | – | – | – | – | – | – | I | – |
| I6. 75-р сургууль | буфет | – | – | – | – | I | – | – | – | – | – | – | – | – | – | I | I |
| I7. ХАА-н дээд сургуулийн хичээлийн байр | буфет | – | I | – | – | I | I | – | – | – | – | – | – | – | – | I | I |
| I8. Нийтийн | зуушны газар | – | – | – | – | – | – | – | I | – | – | – | – | – | I | I | I |
| I9. Шастины нэрэмжит нэгдсэн III эмнэлэг | буфет | – | I | – | – | I | – | – | – | – | – | – | – | – | I | I | I |
| 20. IY хороололд | Пирошкины цех | – | – | – | – | – | – | – | – | – | – | I | – | – | I | I | – |
| 21. Барилгын техникум | буфет | – | – | – | – | – | I | – | – | – | – | – | – | – | – | I | I |
| 22. Наран кафе | Кулинар дэлгүүр | – | – | – | – | – | – | – | – | I | – | – | – | – | I | I | – |
| 23. I хороололд | Пирож газар | – | – | – | – | – | – | – | – | – | – | I | – | – | I | I | I |
| 24. Хүүхдийн больниц | буфет | – | – | – | – | – | – | – | – | – | – | – | – | – | – | I | – |
| 25. Халдвар судлалын нэгдсэн төвд | буфет | – | – | – | – | I | – | – | – | – | – | – | – | – | I | I | I |
| 26. Хими физик техникийн хүрээлэнгийн төвд | буфет | – | I | – | – | I | – | – | – | – | – | – | – | – | – | I | I |
| 27. Районы нэгдсэн эмнэлгийн дэргэд | буфет | – | – | – | – | I | – | – | – | – | – | – | – | – | – | I | I |
| 28. Амгалангийн эцсийн буудал | Хуушуур пирошкины газар | – | – | – | – | – | – | – | – | – | – | – | – | – | I | I | I |
| 29. Уран бар кафе | кафе мороожин | 2 | – | – | I | – | – | – | – | – | – | – | – | – | – | I | – |
| 30. Ард кино театр | | – | – | – | – | I | I | – | – | – | – | – | – | – | – | – | – |
| | ДҮН | 3 | 8 | – | – | I6 | 20 | 9 | 2 | I | – | 2 | – | – | I3 | 24 | I6 |
| 12-р сард | | – | | | | – | | | | | | | | | | | |
| 3-р сард | | – | – | 5 | 2 | – | – | – | I | 3 | 3 | – | I | | | | |
| 5-р сард | | – | – | – | 5 | – | – | – | I | – | 3 | I | – | + | – | – | – |
| | ДҮН | 3 | 8 | 5 | 8 | I6 | 20 | 9 | 4 | 4 | 6 | 3 | I | – | I3 | 29 | I0 |